

Аудит хийгдсэн байгууллага:
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ГУЧИН-УС
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР

Огноо: 2024.02.11

Дугаар: 29/01

ДОТООД АУДИТЫН НЭГЖ: ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН АЛБА

- ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН -

Аудитын нэр: Санхүүгийн аудит

Жил: 2023 он

1 хувийг СХДАА-д
1 хувийг Гучин-Ус сумын ЗДТГ-т

2024 он

АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА: ӨВӨРХАНГАЙ АЙМАГ САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ГУЧИН-УС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
АУДИТЫН ТӨРӨЛ: САНХҮҮГИЙН АУДИТ

АУДИТЫН ХУГАЦАА : 2024.01.15-2024.03.07

Дотоод аудитын нэгжийн дарга:

Аудитын багийн ахлагч: М.ЭРДЭНЭЧУЛУУН

Аудитын багийн гишүүн: Б.ПҮРЭВСҮРЭН

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА
2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ
 - 2.1 Аудитын зорилго
 - 2.2 Аудитын цар хүрээ
3. Байгууллагын сайн туршлага
 - 3.1.Засаглалын удирдлагын талаар
 - 3.2. Эрсдэлийн удирдлагын талаар
 - 3.3.Дотоод хяналтын талаар
4. АУДИТЫН ҮР ДҮН
 - 4.1. Илэрсэн асуудлууд
- 5 НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. ТАНИЛЦУУЛГА

Өвөрхангай аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны дотоод аудитын төлөвлөгөө болон аймгийн Засаг даргын баталсан 29/01 тоот дотоод аудитын ажлын удирдамжийн дагуу Гучин-Ус сумын ЗДТГазрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа иж бүрэн, үнэн зөв, шударгаар хөтлөгдсөн эсэх, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд үр нөлөөтэй дотоод хяналтууд хэрэгждэг эсэх, санхүүгийн үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, шилэн данс хөтлөлт чанартай хийгдэж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт хийх, илэрсэн асуудалд зөвлөгөө өгөхөөр дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн.

Өвөрхангай аймгийн Гучин-Ус сум нь Хөөвөр, Гучин, Аргалант, Аргуйт гэсэн 4 багтай. Сумын нутаг дэвсгэрт төсөвт байгууллага 6, жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээний 14 аж ахуйн нэгж байна. Ерөнхий боловсролын сургууль 1, сургуулийн өмнөх боловсролын байгууллага 1, соёлын төв 1, эрүүл мэндийн төв 1 тус тус үйл ажиллагаа явуулж байна. Шашны байгууллагуудаас шарын шашны 1 байгууллага байна. Улсын нийслэлээс баруун урагш 516 км, аймгийн төв Арвайхээр хотоос урагш 104 км зайтай байдаг.

Тамгын газар нь одоогоор 20 орон тоотойгоор ажиллаж байна. Үүнд: Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, нийгмийн бодлогын мэргэжилтэн, хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн, мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн, бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн, санхүү албаны дарга, багийн Засаг дарга-4, төсөв төрийн сангийн мэргэжилтэн, нягтлан бодогч, архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав, үйлчлэгч, жолооч гэсэн орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулдаг. Интернет сүлжээнд бүрэн холбогдсон. Иргэдэд цахимаар үйлчлэх үйлчилгээг нэвтрүүлэн ажилладаг.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 . Аудитын зорилго:

Сумдын ЗДТГазрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа иж бүрэн, үнэн зөв, шударгаар илэрхийлэгдсэн эсэх, байгууллагын санхүүгийн тайлагналын системд үр нөлөөтэй дотоод хяналтууд хэрэгждэг эсэх, санхүүгийн үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд дотоод аудит хийж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлтэй, дотоод хяналт сул хэрэгжиж буй асуудлыг тодорхойлж, холбогдох заавар, зөвлөмжөөр хангах.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Энэ удаагийн дотоод аудитыг зөвхөн санхүүгийн үйл ажиллагаанд чиглүүлэхийг зорьсон, мөн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн цаг хугацаанд аудитыг багтааж, үр дүнг тайлагнах шаардлагатай тул дээр дурдсан байгууллагын засаглалын бүтэц, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг бүхэлд нь авч үзэхгүй боловч эдгээрийн зөвхөн санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох хэсгийг хамруулна. Мөн Төрийн аудитын газраас санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн зарчим, стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд аудит хийгдэх тул санхүүгийн тайлагналд аудит хийхгүй.

2.3 Аудитын арга, аргачлал

Дотоод аудитаар байгууллагын удирдлагад дотоод аудитын зорилго, хэрэгжүүлэх зарчмаа танилцуулж, засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны талаар асуулга авсан. Мөн аудитын хамрах хүрээнд багтаасан асуудлуудын хүрээнд байгууллагаас олж авсан мэдээлэл, бичиг баримтад дүн шинжилгээ хийж, түүврийн аргаар сорил хийлээ. Аудитын эдгээр горимын үр дүнд, дотоод аудитын баг хангалттай аудитын нотолгоо цуглуулж, аудитын дүгнэлтээ гаргасан болно. Дотоод аудитыг хэрэгжүүлэхэд дараах хууль эрх зүйн баримтуудыг эх үүсвэр болгон ашиглалаа.

- Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт
- Улсын салбарын дотоод аудитын гарын авлага
- Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолууд
- Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 107, 192, 194 дүгээр тогтоолууд
- Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоол
- Сангийн сайдын 2021 оны 190, 2017 оны 347 дугаар тушаалууд
- Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаал

3.БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

Гучин-Ус сумын Засаг даргын Тамгын газар нь сумын төрийн бусад байгууллагууддаа хяналт, үнэлгээ-шинжилгээ хийж, зөвлөн тусладаг.

Өвөрхангай аймгийн 2011, 2013, 2014, 2015, 2016, 2017, 2018, 2019, 2021, 2023 оны шилдэг сумаар нийт 10 удаа шалгарсан.

Байгууллагын ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор “Хүүхэд хөгжлийн өрөө”-г засч, тохижуулан, ашиглалтад оруулсан.

Ажилтан, албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон, үр өгөөжтэй өнгөрүүлэх, мэдлэг, ажлын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор идэвхтэй амралтыг зохион байгуулж, очсон газартай туршлага солилцдог.

3.1 Засаглалын талаар

Гучин-Ус сумын Засаг даргын Тамгын газар нь сумын Засаг даргын ажлын алба бөгөөд Засаг даргын бүрэн эрхийн хугацаанд төрийн удирдлагыг орон нутагт хэрэгжүүлэх, хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, Засгийн газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох зэрэг эрх үүрэг бүхий байгууллага юм.

Тус сумын ЗДТГазар байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулаагүй боловч гол баримтлан ажиллаж байгаа баримт бичиг нь сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр байна. Сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан, сумын ЗДТГазрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг жил бүр гарган, төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж, хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэн, 2023 оны жилийн эцсийн ажлаа 89,9 хувиар дүгнүүлжээ.

Алсын хараа: Хүний хөгжлийг хангасан хүчирхэг эдийн засагтай улсын тэргүүний сум болох

Эрхэм зорилго: Сум орон нутгийн захиргааны байгууллагын чадавхийг дээшлүүлж, төрөлх нутгаа хөгжүүлэх таатай нөхцөлийг хамтын хичээл зүтгэл, оюун ухаан, чадвар чадамжаар бүрдүүлэхэд оршино.

Зорилт: Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэн бүрд шуурхай, чирэгдэлгүй хүргэх нөхцөлөөр хангаж ажиллана гэж тодорхойлжээ.

Засаглах удирдлагын төлөвшлийн ерөнхий үнэлгээ “**Давтамжтай**” буюу 2 дугаар түвшинд үнэлэгдлээ.

3.2 Эрсдэлийн удирдлагын талаар

Байгууллагын хэмжээнд санхүүгийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, эрсдэл үүсэх магадлал бага байгаа хэдий ч үүсэх эрсдэлийг бүртгэлжүүлж, албажуулах, үнэлэх, эрэмбэлэх гэх мэт эрсдэлийн талаар нэгдсэн ойлголт чиг хандлага тогтоогүй гамшгаас хамгаалах төлөвлөгөөнөөс өөр эрсдэлийн эсрэг төлөвлөгөө гаргаагүй, одоогоор эрсдэлийн бүртгэл байхгүй байгаа тул байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвшлийн үнэлгээг үнэлэх боломжгүй байна.

3.3 Дотоод хяналтын системийн талаар

Байгууллагын дотоод хяналтын нэгжийг сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/05 дугаар захирамжаар байгаль орчны хяналтын улсын байцаагчаар ахлуулан хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн, мал аж ахуй хариуцсан мэргэжилтэн, архив бичиг хэргийн ажилтан, нийгмийн бодлогын мэргэжилтэн гэсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмаа батлуулан, 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд

- архив, бичиг хэргийн стандартын талаар ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах,

- шинээр орж ирсэн ажилтан албан хаагчдад хувийн хэрэг бүрдүүлэх талаар заавар, зөвлөгөө өгөх,

- ажилтан албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний багийг байгуулж, дүнг байгууллагын удирдлагад уламжлах,

- санхүүгийн ил тод байдалд хяналт шалгалт хийж дүнг тайлагнах,

- байгууллагын өмч хамгаалах зөвлөлтэй хамтран эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавих,

- дотоод журмын хэрэгжилтэд хяналт тавих,

- орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэлд хяналт тавих зэрэг 7 ажлыг хийхээр төлөвлөгөөнд тусгасан ч 2023 оны 9 дүгээр сард байгууллагын санхүүгийн ил тод байдалд удирдамжтай хяналт хийж илэрсэн зөрчилд зөвлөмж өгч ажилласан боловч бусад ажлуудад тухай бүр удирдамж гаргаагүй, илэрсэн зөрчил тодорхойгүй, төлөвлөгөө оновчгүй боловсруулагдсан, байгууллагын санхүү бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой хяналт хийгдээгүй, дотоод хяналт шалгалтын тайлан байхгүй, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллаагүй, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ харагдахгүй дотоод хяналтыг ор нэр төдий хийдэг нь харагдаж байна. Үүнээс үзэхэд байгууллагын дотоод хяналтын тогтолцооны төлөвшлийн үнэлгээ “Эхлэлийн” буюу 1 дүгээр түвшинд үнэлэгдлээ.

4. АУДИТЫН ҮР ДҮН

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

Илэрсэн асуудал 1	Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэггүй.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал: Эрсдэлийн удирдлагын бодлого журам боловсруулаагүй, эрсдэлээ тодорхойлж, үнэлэн албажуулаагүй, эрсдэлийн эсрэг төлөвлөгөө боловсруулаагүй.	
Байх ёстой шаардлага (шалгуур):	
Асуудлын үндсэн шалтгаан: Эрсдэлийн удирдлага, үнэлгээний ерөнхий ойлголт, ач холбогдол, үнэлгээ хийх арга аргачлалын талаар мэдлэг мэдээлэл муу, засаглах удирдлагаас энэ талаар чиглэл зааварчилгаа өгдөггүй, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхийг шаардсан хууль эрх зүйн зохицуулалт байхгүй.	
Байгууллагад үзүүлэх нөлөө (үр дагавар): Эрсдэлээ тодорхойлоогүй нөхцөлд байгууллага зорилгодоо хүрэхэд саад бэрхшээл тулгарах, байгууллагын үнэ цэнэ буурах, төсөв санхүүгийн хэвийн үйл ажиллагаа алдагдана.	
Зөвлөмж: 1. Эрсдэлийн удирдлагын бодлого, журамтай болох; 2. Байгууллагын ажилтан, албан хаагчдад эрсдэлийн талаар ойлголт өгөх; 3. Жил бүр байгууллагын үйл ажиллагаа, дотоод гадаад хүчин зүйлс болон санхүүгийн зорилтуудад учрах эрсдэлийг шинэчлэн тодорхойлж, тохиолдох магадлал учруулах үр дагавраар нь үнэлэх, албажуулах; 4. Сумын Засаг дарга аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд учирч болох эрсдэлийг үнэлэх; 5. Тухайн эрсдэлийг бууруулах, хүлээн зөвшөөрсөн түвшинд хүртэл удирдах байдлаар төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажиллах; 6. Удирдлагыг эрсдэлийн удирдлагын мэдээллээр хангах; 7. Байгууллагын эрсдэлийн түвшинг үнэлэн шатлал ахиулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	

Илэрсэн асуудал 2	Дотоод хяналтын нэгж хяналтыг ор нэр төдий хийдэг.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал: 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 7 ажлыг хийхээр төлөвлөгөөнд тусгасан ч байгууллагын санхүүгийн ил тод байдалд удирдамжтай хяналт хийж илэрсэн зөрчилд зөвлөмж өгч ажилласан боловч бусад ажлуудад тухай бүр удирдамж гаргаагүй, илэрсэн зөрчил тодорхойгүй, дотоод хяналт шалгалтын тайлан байхгүй, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллаагүй, дотоод хяналтын төлөвлөгөөг эрсдэлд суурилж боловсруулаагүй, байгууллагын санхүү бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой хяналт огт хийгдээгүй, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах мэдлэг дутмаг байна.	
Байх ёстой шаардлага (шалгуур): Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно” гэсэн заалт, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам 4.1. Дотоод хяналт шалгалтыг дараах чиглэлээр зохион байгуулна: 4.1.1. хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын хэрэгжилт болон тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэд тавих хяналт шалгалт; 4.1.2. аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлд хийх хяналт шалгалт; 4.1.3. үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарт тавих хяналт шалгалт; 4.1.4. хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд тавих хяналт шалгалт; 4.1.5. Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт.	
Асуудлын үндсэн шалтгаан: Дотоод хяналтыг хэрхэн хийх талаар мэдлэг ойлголт дутмагаас эрсдэлд суурилсан хяналт хийгддэггүй.	

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

Байгууллагад үзүүлэх нөлөө (үр дагавар):

Байгууллагад гарч байгаа эрсдэл дахин давтагдах, дээд шатны байгууллагуудын хяналт, уялдаа холбоо байхгүй, хяналт дутуу, чанаргүй хийгдэх, хяналтын дүгнэлт бодитой бус гарах.

Зөвлөмж:

1. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд дотоод хяналтын нэгжийн ажлыг үнэлэн, биелэлтийг тооцож үр дүнд суурилсан урамшууллыг хууль тогтоомжид нийцүүлэн олгох асуудлыг тусгаж өгөх
2. Санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг эрс сайжруулах.
3. Дотоод хяналтын нэгжийн албан хаагчийг холбогдох мэргэшүүлэх байгууллагын сургалтад хамруулж мэргэшүүлэх.
4. Дотоод хяналтын нэгжийн жилийн төлөвлөгөөг эрсдэлд суурилан төлөвлөх.
5. Дотоод хяналтын зураглалтай болгох, түүнийг хамт олноороо мөрддөг байх.

Илэрсэн асуудал 3	Захирамж, тушаал шийдвэрээр хөрөнгө зарцуулсан боловч анхан шатны баримт дутуу, зарцуулалтын тайлан гаргадаггүй.
--------------------------	--

Асуудлын ангилал	Нөлөө их
-------------------------	----------

Бодит байдал:

Сумын Засаг даргын 2023 оны А/21 дүгээр захирамжаар үндэсний шагайн харваан аймгийн гоц мэргэчүүдэд хүндэтгэл үзүүлэхэд 1,140,000 (нэг сая нэг зуун дөчин мянга) төгрөг, 2023 оны А/24 дүгээр захирамжаар улс, аймаг, сумын аварга малчид, сумын аварга удирдах ажилтан, малд нүдтэй хүүхэд, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнд хүндэтгэл үзүүлэх зардалд 3,910,000 (гурван сая есөн зуун арван мянга) төгрөг, А/30 дугаар захирамжаар Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлийн уулзалт, золголтын зардалд 2,025,000 (хоёр сая хорин таван мянга), А/46 дугаар захирамжаар 765,000 (долоон зуун жаран таван мянга) төгрөг, а/85 дугаар захирамжаар 390,000 (гурван зуун ерэн мянга) төгрөг, А/90 дугаар захирамжаар овооны тахилгын зардалд 1.000.000 (нэг сая) төгрөг, А/99 дүгээр захирамжаар малчдын бүсийн зөвлөгөөний цайны зардалд 229,000 (хоёр зуун хорин есөн мянга) төгрөг, А/108, А/144 дугаар захирамжаар нутгийн зөвлөлийн уулзалтын зардалд 3,549,000 (гурван сая таван зуун дөчин есөн мянга) төгрөг, А/146 дугаар захирамжаар улсын бүсийн тэмээчдийн баяр-2023 арга хэмжээний зардалд 189,800 (нэг зуун наян есөн мянга найман зуу) төгрөг, А/154 дүгээр захирамжаар ахмадын өргөө-ний засварын зардалд 1,000,000 (нэг сая) төгрөг нийт **14,197,800** (арван дөрвөн сая нэг зуун ерэн долоон мянга найман зуу) төгрөгийг зарцуулсан боловч юунд зарцуулсан тайлан байхгүй, холбогдох байгууллагын хүсэлтийг хавсаргаагүй зөрчил илэрсэн.

Байх ёстой шаардлага (шалгуур):

“Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 6.2-т “Нөөц хөрөнгийн зарцуулалтын тайланг санхүүжүүлсэн зардал, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсөвтэй зэрэгцүүлэн гаргаж, байгууллагын дарга, нягтлан бодогч нар гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулан холбогдох баримтыг хавсаргана.”

Асуудлын үндсэн шалтгаан:

Захирамж, тушаал шийдвэрээр хөрөнгө зарцуулахдаа анхан шатны баримтын бүрдэл дутуу, нягтлан бодогчоор ажиллаж байсан албан хаагчид ажилдаа хайнга хандсан, удирдах албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангах мэдлэг муу, няравтаа шаардлага тавьж ажиллаагүй, ажлын хариуцлагагүй байдлаас үүсчээ.

Байгууллагад үзүүлэх нөлөө (үр дагавар):

Анхан шатны баримтын бүрдэл дутуу, бараа материалыг бүрэн гүйцэд орлого авч, зарцуулалтыг хийхгүйгээс төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах, хяналтгүй зарцуулалтаас үүдэн ашиглангийн үйлдэл гарах, санхүүгийн зөрчил нэмэгдэх, улмаар төлбөрийн акт тавигдах, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа доголдох, санхүүгийн тайланд зөрчилтэй дүгнэлт авах зэрэг эрсдэлүүд үүсэхээр байна.

Зөвлөмж:

1. Захирамж, тушаал шийдвэрээр хөрөнгө зарцуулахдаа нэхэмжлэх, зарлагын баримтыг бүрэн гүйцэт хавсаргаж хэвших
2. Захирамж, тушаал шийдвэрийн дагуу худалдан авсан шагнал, бэлэг дурсгал болон бусад холбогдолтой бараа материалыг эд хариуцагч няравын тайланд орлого авахуулан зарцуулалтыг хийж байх, шууд зардалд бичиж байгаа үйл ажиллагааг таслан зогсоох
3. Шагнал, бэлэг олгосон жагсаалтыг үйлдэн хүлээн авсан хүнээр гарын үсэг зуруулж баталгаажуулж байх
4. Зарцуулалт хийх захирамж гаргахдаа тухайн захирамжийн төсөлд хувийн хэрэг нээж түүнд иргэд болон байгууллагаас ирүүлсэн хүсэлт, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон түүнд

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

шаардагдах хөрөнгийн хэмжээг зөв бодитой тооцсон эсэхийг холбогдох норм, норматив, тарифаар тооцоог гаргаж хавсаргаж байх

Илэрсэн асуудал 4	Томилолтын хуудас засвартай, хүчин төгөлдөр бус томилолтын хуудсаар томилолтын мөнгө олгосон.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
<p>Бодит байдал: 2023 оны касс харилцахын баримтыг шалгахад эх хувь томилолтын хуудас байхгүй, канондсан томилолтын хуудсаар Засаг дарга Х.Энхтайван, дугаар багийн Засаг дарга Ш.Цэрэнтогмид, дүгээр багийн Засаг дарга А.Баярмөнх, дугаар багийн Засаг дарга М.Цэрэнбанзрагч, Засаг даргын Тамгын газрын дарга Н.Тунгалаг нарт нийт 576,000 (таван зуун далан зургаан мянга) төгрөг, хууль эрх зүйн мэргэжилтэн Л.Мөнхжавхаад 28,000 (хорин найман мянга) төгрөг нийт 604,000 (зургаан зуун дөрвөн мянга) төгрөг, сумын Засаг даргын Тамгын газрын дарга Н.Тунгалаг сумын хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдийн сургалтад хамраглахад зөвшөөрсөн гарын үсэг засвартай байхад 236,000 (хоёр зуун гучин зургаан мянга) төгрөг хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Даваажаргалын сумын худалдан авах ажиллагаа хариуцсан албан хаагчдад зориулсан сургалтын томилолтын ирсэн буцсан он сар өдрийг бичээгүй байхад 56,000 (тавин зургаан мянга) төгрөг олгосон, сумын Засаг дарга Х.Энхтайван 2023 оны 11 дүгээр сарын 23-25-ны өдрийг дуустал Өвөрхангай аймгийн Цэргийн штабаас зохион байгуулсан сумын Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтын томилолтын хуудасны ирсэн буцсан тэмдэглэлд сургалт зохион байгуулсан байгууллагын тамга тэмдэг бус Гучин-Ус сумын Засаг даргын тамгыг дарж, хүчин төгөлдөр бус хуурамч баримтаар 236,000 (хоёр зуун гучин зургаан мянга) төгрөгийг олгосон, албан томилолттой холбоотой нийт 1,132,000 (нэг сая нэг зуун гучин хоёр мянга) төгрөгийн зөрчил илэрч, 236,000 (хоёр зуун гучин зургаан мянга) төгрөгийн томилолтод улсын ахлах байцаагчийн акт тогтоолоо.</p>	
<p>Байх ёстой шаардлага (шалгуур): Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журмын 2.10. Унааны зардлын баримт (онгоц, галт тэрэг, хот хоорондын нийтийн тээврийн тасалбар, автомашин хөлсөлсөн бол ажил гүйцэтгэх гэрээ эсхүл шатахуун худалдан авсан тасалбар)-ыг төрийн албан хаагч албан томилолтын тайландаа хавсаргах ба хоолны болон байрны зардлын баримтыг албан томилолтоор ажилласан төрийн албан хаагчаас шаардахгүй байж болно. Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын 1-т Анхан шатны баримт гэж ажил гүйлгээ гарсныг нотолж бичгээр бүрдүүлсэн болон бусад нотолгоог хэлнэ. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. Аж ахуйн нэгж, байгууллага нь анхан шатны маягтуудыг нэгдсэн журмаар урьдчилан дугаарлана. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ.</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Санхүүгийн үйл ажиллагаанд тухай бүр шат дараалсан хяналтыг тавьдаггүй, ажилдаа хайнга хандсан зэргээс үүдэлтэй байна.</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө (үр дагавар): Санхүүгийн зөрчил нэмэгдэх, улмаар төлбөрийн акт тавигдах, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа доголдох, төсөв хүрэлцэхгүй болох эрсдэлтэй.</p>	
<p>Зөвлөмж: 1. Албан хаагчдын томилолтын хуудас засвартай, гүйцэтгэлийн тайлан бичээгүй, зөвшөөрсөн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг зурагдаагүй тохиолдолд томилолтын зардал олгодог байдлыг таслан зогсоох, анхан шатны баримт бүрэн бүрдсэний дараа зардлыг олгож хэвших, зардлын гүйлгээнд тавих хяналтыг сайжруулах. 2. Анхан шатны баримтын бүрдэлд Төрийн сан хяналт хийсний үндсэн дээр гүйлгээг баталдаг байх.</p>	

Илэрсэн асуудал 5	Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан.
Асуудлын ангилал	Нөлөө дунд
<p>Бодит байдал: Тухайн байгууллага нь 2023 онд хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардлаас 6,600,000 (зургаан сая зургаан зуун мянга) төгрөгийн хог тээврийн машины жолоочийн цалин хөлсийг олгосон мөн шуудан, холбоо, интернетийн төлбөрийн зардлаас сумын цахим хуудасны төлбөрт 280,000 (хоёр зуун наян мянга) төгрөг нийт 6,880,000 (зургаан сая найман зуун наян мянга) төгрөгийн зориулалт бус зарцуулалт илэрлээ.</p>	
<p>Байх ёстой шаардлага (шалгуур): Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын заалтуудыг тус тус зөрчсөн тул Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д заасан “Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуй нэгж, албан тушаалтанд шаардлага тавьж хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах” заалтууд</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Сумын төрийн сан, санхүү албаны дарга, төсвийн шууд захирагчийн хяналт сул байгаагаас шалтгаалсан.</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө (үр дагавар): Төсвийн хөрөнгийг зориулалт бус, үр ашиггүй зардалд зарцуулснаар батлагдсан төсөв дутагдах эсвэл хэтрэх, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа доголдох зэрэг эрсдэлүүд үүсэх магадлалтай.</p>	
<p>Зөвлөмж: 1. Төсвийн захирагч төсвийг батлагдсан төсвийн хүрээнд, зориулалтын дагуу зарцуулж байх. 2. Төсвийн хөрөнгөөс зохих зөвшөөрөлгүйгээр зориулалт бусаар зарцуулж байгааг таслан зогсоох 3. Анхан шатны баримтын бүрдэл, түүний агуулга, хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг төсвийн шууд захирагч, төрийн сан, санхүүгийн албаны дарга нар тогтмол, чанартай тавьж ажиллах 4. Мэргэжлийн байгууллагуудаас заавар, зөвлөгөөг тогтмол авч ажиллах</p>	

Илэрсэн асуудал 6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй
Асуудлын ангилал	Нөлөө дунд
<p>Бодит байдал: Бодлогын баримт бичиг нь тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлээ хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэх, боловсруулах, тайлагнахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг нэг дор багтаасан дүрэм, журам, заавар бөгөөд тус байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүйгээр санхүүгийн үйл ажиллагаагаа хөтлөн явуулдаг.</p>	
<p>Байх ёстой шаардлага (шалгуур): Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана. 18.5.Нягтлан бодогчийн нэг орон тоотой аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа нягтлан бодогч, эсхүл гэрээт нягтлан бодогч нь ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэнэ. 20.2.Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.2.аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан: НББ-ийн бодлогын баримт бичиг боловсруулахын тулд өөрсдийгөө дайчлан мэдлэг олж авахыг хичээдэггүй, бэлэнчлэх сэтгэлгээтэй, санал санаачлага муутайгаас үүдэлтэй байна.</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө (үр дагавар): Байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн үндэсний болон холбогдох стандарт, журам баталж, мөрдүүлээгүй нь олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргасан эсэхийг үнэлэхэд сөрөг нөлөө үзүүлэх, байгууллагын онцлогийг тайлбарлах боломжгүй болох эрсдэлийг дагуулж байна.</p>	

Зөвлөмж:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулахын тулд мэргэжлийн байгууллагуудаас заавар, зөвлөгөө, сургалт авах
2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулан баталж, мөрдөж ажиллах

5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ


Дотоод аудитаар танай байгууллагад “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгч байна.


Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн Тайлбар
<p>Сайжруулах шаардлагатай</p>	<p>Байгууллагын засаглалын төлөвшил “Давтамжтай буюу 2 дугаар түвшин”-д, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “Эхлэлийн буюу 1 дүгээр түвшин”-д байна гэж үзсэн.</p> <p>ЗДТГазрын дарга, дотоод хяналтын нэгж, холбогдох албан тушаалтнууд хууль тогтоомжийг бүрэн судлаж, хэрэгжүүлж ажиллах, эрсдэлд суурилсан дотоод хяналтыг тавьж ажиллахад анхаарч дотоод хяналтын нэгжийн ажилтнуудыг сургалтад хамруулж чадавхжуулах, санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг эрс сайжруулах, санхүүгийн ажилтнууд өөрсдийн санхүүгийн мэдлэгээ дээшлүүлэхийн тулд ажлын байран дээрээ тогтмол суралцах, удирдлагын багийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах, ажлаа сайжруулах, чанаржуулах, төрийн сан төсвийн байгууллагуудын гүйлгээг батлахдаа холбогдох анхан шатны баримтын бүрдэл, зардлын зориулалт зэрэгт хяналт тавьж, шаардлага хангаагүй хууль тогтоомж зөрчсөн гүйлгээг батлахгүй байх шаардлагатай гэж дүгнэлээ. Аудитаар нийт 6 асуудал илэрсэн. Үүнээс тухайн 4 асуудал буюу нийт асуудлын 66.6 хувь “нөлөө ихтэй” гэж үзсэн.</p>

Дотоод аудитаар нийтдээ 23 заалт бүхий зөвлөмж өглөө. Зөвлөмжийн хэрэгжилтийг хавсралт дахь маягтаар гарган 2024 оны 07 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг байгууллагын дарга, нягтлан бодогч нарт үүрэг болгож байна.


ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ АУДИТОР  Б.ПҮРЭВСҮРЭН

ТАЙЛАН ХЯНАСАН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА  М.ЭРДЭНЭЧУЛУУН

ТАНИЛЦААН:
ГУЧИН-УС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  Н.ТУНГАЛАГ

НЯГТЛАН БОДОГЧ  Ө.БАДАМЗУЛ





ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
АЛБА

УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 29/01/05

Арвайхээр сум

Зөрчил арилгуулах тухай

Өвөрхангай аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны дотоод аудитын төлөвлөгөө болон аймгийн Засаг даргын баталсан 29/01 тоот дотоод аудитын ажлын удирдамжийн дагуу 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Б.Пүрэвсүрэн нар дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудитаар Тухайн байгууллага нь 2023 онд хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардлаас хог тээврийн машины жолоочид 1-12 сард нийт 6,600,000 (зургаан сая зургаан зуун мянга) төгрөгийн цалин хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн тул Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д заасан "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуй нэгж, албан тушаалтанд шаардлага тавьж хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах" гэсэн улсын байцаагчийн бүрэн эрхийнхээ хүрээнд ШААРДАХ нь:

1. Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгааг таслан зогсоох.

2. Төлөвлөгдөөгүй зардал зайлшгүй гарах нөхцөл үүссэн тохиолдолд Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын хүрээнд зардал, бүлэг хооронд зохицуулалт хийгдсэний дараа ажил гүйлгээг хийж хэвших.

692905006

Энэхүү албан шаардлагын биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 31-ний дотор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан ёсоор ирүүлэхийг Гучин-Ус сумын ЗДТГ-ын дарга Н.Тунгалаг, нягтлан бодогч Ө.Бадамзул нарт үүрэг болгов.

Албан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд Монгол улсын “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 16.1, 16.2-т заасны дагуу хариуцлага тооцох болно.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

М.ЭРДЭНЭЧУЛУУН

АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Б.ПҮРЭВСҮРЭН

ХҮЛЭЭН АВСАН:

ГУЧИН-УС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Н.ТУНГАЛАГ

НЯГТЛАН БОДОГЧ

Ө.БАДАМЗУЛ





ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
АЛБА
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АКТ

2024 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 29/01/04

Арвайхээр сум

Хүчингүй томилолтын хуудсаар олгосон
томилолтын зардлыг буцаан төлүүлэх тухай

Өвөрхангай аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны дотоод аудитын төлөвлөгөө болон Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан 29/01 дүгээр удирдамжийн дагуу Гучин-Ус сумын ЗДТГазрын 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Б.Пүрэвсүрэн дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудитаар сумын Засаг дарга Х.Энхтайван 2023 оны 11 дүгээр сарын 23-25-ны өдрийг дуустал Өвөрхангай аймгийн Цэргийн штабаас зохион байгуулсан сумын Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтын томилолтын хуудасны ирсэн буцсан тэмдэглэлд сургалт зохион байгуулсан байгууллагын тамга, тэмдэг бус Гучин-Ус сумын Засаг даргын тамгыг дарж, хүчин төгөлдөр бус баримт үйлдэж 236,000 (хоёр зуун гучин зургаан мянга) төгрөгийн томилолтын зардал олгосон нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын 1-т Анхан шатны баримт гэж ажил гүйлгээ гарсныг нотолж бичгээр бүрдүүлсэн болон бусад нотолгоог хэлнэ. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. Аж ахуйн нэгж, байгууллага нь анхан шатны маягтуудыг нэгдсэн журмаар урьдчилан дугаарлана. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн тул "Төрийн хяналт шалгалтын тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.12.2-д "аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж

69298083

улсын орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх” гэсэн улсын /ахлах/ байцаагчийн бүрэн эрхийнхээ хүрээнд ТОГТООХ нь:

1. Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар олгосон томилолтын зардал 236,000 (хоёр зуун гучин зургаан мянга) төгрөгийг сумын Засаг дарга Х.Энхтайвангаар төлүүлж, аймгийн төсвийн орлогын Төрийн сангийн банкин дахь 100100000988 тоот дансанд төвлөрүүлэх;

Энэхүү актын биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан ёсоор ирүүлэхийг Гучин-Ус сумын ЗДТГ-ын дарга Н.Тунгалаг, нягтлан бодогч Ө.Бадамзул нарт хариуцуулав.

Энэхүү актын талаар Улсын ерөнхий байцаагч бөгөөд Сангийн сайдад 14 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй.

АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН

М.ЭРДЭНЭЧУЛУУН

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Б.ПҮРЭВСҮРЭН

АКТЫГ ХҮЛЭЭН АВСАН:

ГУЧИН-УС СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Н.ТУНГАЛАГ

НЯГТЛАН БОДОГЧ

Ө.БАДАМЗУЛ

